

БАТЛАВ. ЦДҮС ТӨХК-ИЙН ТӨВИЙН БҮСИЙН САЛБАРЫН ДАРГА

Ж.МӨНХЖАРГАЛ

**ХӨТӨЛ ДЭД СТАНЦ ОПУ, ЗРУ-ЫН ДОТОР, БАРИЛГЫН ДЭЭВРИЙН ЗАСВАР,
ГАДНА ФАСАДНЫ ЗАСВАР, БАРИЛГЫН ХАЯАВЧ, БОРООНЫ УС ЗАЙЛУУЛАХ
ШУУДУУ ЗАСВАРЛАЖ ЦУТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: *“Хөтөл дэд станц ОПУ, ЗРУ-ын дотор, барилгын дээврийн засвар, гадна фасадны засвар, барилгын хаяавч, борооны ус зайлуулах шуудуу засварлаж цутгах ажил”*

Төслийн дугаар: *ЦДҮС-2019/ТБС-ХА-04*

2019 оны 07-р сарын 29-ны өдөр

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019 оны 07-р дугаар сарын 29-ны өдөр

Үнийн саналын урилга

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ны Төвийн бүсийн салбар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“Хөтөл дэд станц ОПУ, ЗРУ-ын дотор, барилгын дээврийн засвар, гадна фасадны засвар, барилгын хаяавч, борооны ус зайлуулах шуудуу засварлаж цутгах ажил”** гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерийг 2019 оны 08 дугаар сарын 05-ны 15:00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг Дархан-Уул аймаг, Дархан сум, 15-р баг Үйлдвэрчний район “ЦДҮС” ТӨХК-ийн Төвийн бүсийн салбарын төв байр, 2-р давхар 205 тоотод 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 15:20 цагт тендерийг нээнэ.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дархан-Уул аймаг, Дархан сум, 15 дугаар баг Үйлдвэрчний район
“ЦДҮС” ТӨХК-ийн Төвийн бүсийн салбарын төв байр
Захирга аж ахуйн алба
Утас:7037 3852, 95959565, 99017500 Факс: 976-7037 3225

Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Хоёр.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| <p>ТӨӨЗ- НЫ холбогд ох заалт</p> | <p align="center">Шалгуур үзүүлэлт</p> |
|---|--|
| <p>ТӨӨЗ 1.1</p> | <ol style="list-style-type: none"> 1. Үнийн санал маягтын дагуу ирүүлэх 2. Улсын бүртгэлийн гэрчилгээ; /нотариатаар баталгаажуулж ирүүлнэ/ 3. Татварын тодорхойлолт; 4. Нийгмийн даатгалын тодорхойлолт; 5. Барилгын угсралтын 2.1.1, 2.1.2-ын тусгай зөвшөөрөлтэй байх 6. Сүүлийн нэг жилийн буюу 2018 оны санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/; 7. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаархи мэдээлэл ирүүлнэ. /сүүлийн 2 жил / 8. Сүүлийн 2 жилийн ижил төстэй ажил гүйцэтгэсэн талаар / гэрээний хуулбар комиссын акты хуулбар хавсарган ирүүлэх/ 9. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт 10. Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн эсэх талаар Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тодорхойлолт ирүүлнэ; 11. Ажил гүйцэтгэх график; 12. Ажилчидын мэргэжлийн ур чадварын тодорхойлолт, туршлагын талаар /голлох мэргэжилтний мэргэжлийн үнэмлэхний хуулбар, Нийгмийн даатгалын гэрчилгээний хуулбар/ Голлох инженер нь барилгын инженер бөгөөд мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх 13. Техникийн тодорхойлолтод заасан ажлын даалгавар, ажлын тоо хэмжээний дагуу төсөв хийж ирүүлнэ. Төсвийг Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэж буй төсөв зохиох программаар гүйцэтгэж эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. 14. Тендерт оролцогч нь санал болгож буй үнийн дүнд багтаан тухайн ажлыг стандартын дагуу чанартай хийж дуусган хүлээлгэн өгөх, чанарын баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. 15. Тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн жагсаалт ирүүлнэ. 16. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга; <p align="center">Жич: Дээрх баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p> |

| | |
|---------------------------|---|
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Огноо: Тендерийг 2019 оны 08 дугаар сарын 05-ны Цаг: 15 цаг 00 минут.</p> |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, 15-р баг Үйлдвэрчний район “ЦДҮС” ТӨХК-ийн Төвийн бүсийн салбарын төв байр Давхар болон өрөөний дугаар: 2-р давхар 205 тоотод</p> <p>Огноо: 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдөр нээлт хийнэ. Цаг: 15:20</p> |
| ТӨӨЗ 6.2 | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаараас бүрдэнэ: “Хөтөл дэд станц ОПУ, ЗРУ-ын дотор, барилгын дээврийн засвар, гадна фасадны засвар, барилгын хаяавч, борооны ус зайлуулах шуудуу засварлаж цутгах ажил” ЦДҮС-2019/ТБС-ХА-04</p> |
| Бусад | <p>Хөнгөлөлт урамшуулал үзүүлэх бол албан бичгээр ирүүлнэ.</p> |

Гурав.ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ



Батлав: Ерөнхий инж: М.Чулуунбаатар

АШУА-ны 2019 оны их засварын төлөвлөгөө

Объектын нэр: 110/35/6 кВ-ын Хөтөл дэд станц ОПУ, ЗРУ-ын барилгын дээврийн засвар, гадна фasadны засвар, их засварын ажлын эзэлхүүн

Хийгдэх ажлын нэр төрөл

2019 он 03 сар 07 өдөр

| № | засвараар хийх ажил | х/н | тоо | хэмжээ | тайлбар |
|---|---|-----|------|--|---|
| 1. ОПУ-д шинээр дис-н өрөө хийх | | | | | |
| 1 | Диспетчерийн өрөөг ОПУ-д Вакум хаалтаар хийх /нэг өргөн, урт хоёр талыг хийх/ | м2 | 19.4 | Өргөн=3.84м, урт=5м Өндөр=2.40м | Хаалганы өргөн=0.9м, өндөр 2м нийт 1.8м2 хаалга хэмжээ хасаж тооцов. |
| 2 | Вакум хаалтын хаалга | м2 | 1.8 | өргөн=0.9м, өндөр 2м | 1 ширхэг хаалга хийх. Хаалганы өргөн=0.9м, өндөр 2м /буулгасан хаалга ашиглана/ |
| 3 | Диспетчерийн өрөөний дээврийг галд тэсвэртэй Кнауф-Акустика хавтан /1998*1188*12,5мм/-аар хийх. | м2 | 19.2 | Өргөн=3.84м, урт=5м | Тааз эмульсээр будна. |
| 4 | Панелуудын зөөсөн хэсгийн нүхийг бөглөх | м2 | 5.75 | Урт-2.76м, өргөн-0.8м, урт-6.44м өргөн- 0.55 м | Нүхийг 0.5см зузаантай лист төмрөөр бөглөх |
| 5 | Диспетчерийн өрөөны шал тэгшилэх | м2 | 14.4 | Өргөн=3.84м, урт=5м | |
| 6 | Диспетчерийн өрөөнд сайн чанарын паркетэн шал хийх | м2 | 14.4 | Өргөн=3.84м, урт=5м | |
| 7 | Вакум цонх хийх | м2 | 1.9 | 1.25*1.55 | ОРУ талын ханыг цоолж цонх гаргана. Цонхны амалгааг шавардаж чулуун тавцан хийнэ. |
| 8 | Монтажны утас | м | 50.0 | ППВ-2*1.8 | Өрөөний цахилгаан хэрэгслийг нэг шитний системд оруулах |
| 9 | Аваарийн гэрэл | ш | 1 | Тогтмол 220в цэнэглэдэг | |
| 10 | Лед нэмэх гэрэл | ш | 2 | 30 ВТ | |
| 11 | унтраалга /ил/ | ш | 2 | ил | |
| 12 | разетка | ш | 2 | ил | |
| 13 | Шитний хайрцаг | ш | 1 | 30*20 | |
| 14 | Автомат | ш | 1 | 25А | |
| 15 | Автомат | ш | 3 | 16А | |
| 2. Гал тогооны өрөө ашиглалтын инженерийн өрөөг нэгтгэж амралтын өрөө хийх | | | | | |
| 1 | Ашиглалтын инженерийн өрөөний 3 талын модон панерин ханыг буулгах | м2 | 26.8 | ханын урт=9.23м, өндөр=2.67м | Цонх, хаалганы хэмжээ хасагдана. Цонх 1.26*1.56 /1.96м2/ Хаалга 1.03*2.10 /2.16/ |
| | Хананд шаврын засвар хийх | м2 | 10.0 | | |
| 2 | Дотор хана эмульсдэх | м2 | 22.0 | урт=12.8м, өндөр=2.67м | Цонх, хаалганы хэмжээ хасагдана. Цонх 1.26*1.56/1.9656м2/, Хаалга 1.03*2.10/2.163м2/. |
| 3 | Цонхны 3 талын панеран хэсгийг буулгах | м2 | 2.0 | Цонхны өргөн -1.26м, урт-1.56м, Тавцаны өргөн - 1.26м, урт-1.56м, Хажуу 2 талын ханын өргөн - 0.45м, өндөр-1.60м | |
| 5 | Нэмэх лед гэрэл | ш | 2 | 220в 30вт | |
| 6 | Монтажны кабель | м | 20 | ппв-2*1.8 | Монтаж, разетка, унтраалгыг |

| | | | | | | |
|--------------------------------|---|----|------|---|--|--------|
| 7 | унтраалга | ш | 1 | | далд суулгаж хийх | |
| 8 | розетка | ш | 2 | | | |
| 9 | Хуучин 12 см бетон ханыг арклан буулгах | м3 | 0.8 | өндөр -2.50м, урт-2.50м | Өргөтгөлийг өндөр -2.50м, урт-2.50м /ашиглалтын инженерын өрөө, гал тогоо хоорондох хуучин ханыг арклан буулгаж нэгтгэн амралтын өрөө хийх. | |
| 10 | Буулгасан ханын шал хэсэгт плита наах | м2 | 0.4 | өргөн -0.12м, урт-2.50м өндөр-0.03м | өргөн -0.12м, урт-2.50м өндөр-0.03м /ашиглалтын инженерын өрөө, гал тогоо хоорондох хуучин ханыг арклан буулгаж нэгтгэн амралтын өрөө хийх. | |
| 11 | Гал тогооны 1ш хаалга буулгаж тоосгоор өрж 2 талд өнгө шавар хийж гадаргууг тэгшлэх | м2 | 2.87 | Өндөр-2.05м өргөн-0.7м | Хаалга 0.7*2.05/1.435м2/. 2 талыг Будах, эмүльсдэх хэмжээ коридор болон амралтын өрөөний дотор заслын эзэлхүүнд орсон. | |
| 12 | Чийгтэй нөхцөлд ажиллах гипсэн тааз хийж, гадаргууг тэгшлэж цагаан өнгийн эмүльсээр будна | м2 | 16 | өргөн -2.50м, урт-6.40м | | |
| 13 | Агааржуулалтын PVC цагаан 80 см хоолой | м | 2 | Цагаан өнгийн PVC | Агааржуулагч хоолой гаргах | |
| 14 | 80 см цагаан PVC булан | ш | 1 | | | |
| 15 | 80 см цагаан PVC сэткэ | ш | 1 | | | |
| 16 | 80 см төмөр агаар сорогч сэнс | ш | 1 | | | төмөр |
| 17 | PVC хоолой тогтоогч | ш | 20 | | | төмөр |
| 18 | Шахдаг хөөс | ш | 2 | | | Герман |
| 19 | Амралтын өрөөнд наар хийх | ш | 1 | Өргөн - 2.5м Урт - 2.2м Өндөр-0.6м | Наарны дээд тавцан хэсэг болон өргөн 1 талыг хар фанер, банз, өнгөт хавтангаар хийнэ. Наарны тавцан-5.5м2. Наарны доод өргөн суурь-1.5м2. Зөөлөн шахмал эсгийгээр зөөлөвч хийж өнгө материалаар бүрнэ. | |
| 3. Сургалт, хурлын заал | | | | | | |
| 1 | Вакум хаалт хийх | м2 | 10 | өндөр -2.95м, урт-3.6м | Хаалганы өргөн-0.6м, өндөр-1.8м нийт 1.08м2 хаалга хэмжээ хасаж тооцов. Гал тогооноос буусан хаалгыг хаалтанд хийнэ. Сургалтын өрөөний ар талд вакум хаалт хийж агуулах хийх. | |
| 1 | Хана будах /Эмүльсдэх/ | м2 | 21.0 | өндөр -3м, урт-12.1м | цонх, хаалганы хэмжээг хасав. Хаалга өргөн-0.9м, өндөр-2.10м, Цонх өндөр 1.25м урт-3.1м | |
| 2 | Нэмэх лед гэрэл | ш | 2 | 220в 30вт | Монтаж, розетка, унтраалгыг далд суулгаж хийх | |
| 3 | Монтажны утас | м | 30 | ППВ-2*1.8 | | |
| 4 | Унтраалга | ш | 1 | | | |
| 5 | Розетка | ш | 1 | | | |
| 4. Коридор | | | | | | |

| | | | | | |
|------------------------|---|----|-------|---|--|
| 2 | Хана тосон будгаар будах | м2 | 38.0 | өндөр -2.78м, урт-16.1м | 3ш хаалганы хэмжээ хасагдана. 1.өргөн-0.9м, өндөр- 2.10м/1.89м2/, 2.Хаалганы өргөн=0.8м, өндөр 2м/1.6м2/ 3.Хаалга 1.03*2.10/2.163м2/ Өнгийг тухайн үед нь сонгох. |
| 5. Гадна засвар | | | | | |
| 1 | Гадна заадас чигжиж шавардах | м2 | 8.00 | өргөн 0,08м, урт-99м,зузаан- 0,1м | 18 ш заадас |
| 3 | Барилгын ус зайлуулагч хаяавчийн суулт чигжих, засварлан бетондох | м3 | 7.74 | урт-86м, өргөн- 1.5м | |
| 2 | Ус зайлуулах сувгийн шуудуу сэргээж ухах | м3 | 11 | | |
| | Ус зайлуулах суваг бетондох | м3 | 3.8 | | |
| 6 | Гадна фасад эмульсдэх | м2 | 562.0 | Урт-105м, өндөр-5.5м /барилгын өндөр-5.5м өргөн-9.5м, Урт- 43/ | Цонх /153*1.26м/-ын 4ш=7.7112м2 хасагдана. ОПУ-д шинээр хийх 1ш цонхны хэмжээг оруулав. Урд талын хаалганы өргөн-0.9м, өндөр-2.10м/1.89м2/, ар талын хаалга өргөн-2.12, өндөр-2.80м/5.936м2/. Нийт гадна талын хаалга-7.826м2 |
| 6 | Гадны хаалга солих | ш | 1 | өргөн-0.9м, өндөр-2.10м | Бүргэд |
| 6. Дээвэр | | | | | |
| 1 | Хуучин хар цаасыг бүрэн хуулах | м2 | 451.5 | Дээврийн өргөн=10.5м, урт=44м | Дээврийн өргөн 2 талын хана дээврээс дээшээ 0.5м /1м/ -ыг нэмэх. |
| 2 | Барилгын дээвэрт цементэн хучилт хийх | м2 | 451.5 | Дээврийн өргөн=10.5м, урт=43м | Дээвэрт 1.5-2см-ын зузаан цементэн давхрага хийх |
| 3 | Хучилтанд бэхжүүлэгч хийх | м2 | 451.5 | Дээврийн өргөн=10.5м, урт=43м | Дээврийн өргөн 2 талын хана дээврээс дээшээ 0.5м /1м/ -ыг нэмэх. Дээврийн өргөн 2 талын хана дээврээс дээшээ 0.5м /1м/ - ыг нэмэх. |
| 4 | Халааж наадаг чулуугүй болон чулуутай хар цаасаар бүрэх /Технониколь/ | м2 | 462.0 | Дээврийн өргөн=10.5м, урт=43м | Дээврийн өргөн 2 талын хана дээврээс дээшээ 0.5м /1м/ -ыг нэмэх. |
| 5 | Парлетын төмөр солих | м | 19.0 | Ханын өргөн=0.55м, урт=19м | Өргөн талын босоо хэсгийн парпед |
| 6 | Амралтын өрөөний паар, цэвэр усны шугам ханаруу шахаж шилжүүлэх, гал тогооны тосгуурыг цааш нь зөөж байршуулах, паар солих. | | | | Kils-900 загварын 20ш секц, Ф25- ын 20м PVC хоолой булан-4ш, ханын тогтоогч-10ш, Гуулин хаалт- 3ш |

Хянасан:

АШУА-ны дарга:/Л.Гэрэлмаа/
АШУА-ны Төсвийн инженер:/Б.Мөнгөнтуяа/
АШУА-ны Ашиглалтын инженер:/А.Батбаяр /

Эзэлхүүн гаргасан:

Хөтөл-Орхон дэд станцын Ашиглалтын инженер:/Д.Шүрэнчимэг/

Дөрөв.**ЖИШИГ МАЯГТ**
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(**Захиалагч байгууллагын нэр**)-ын дарга _____ танаа

1. Бид, [**тендерт оролцогчийн нэр**], [**гэрээний нэр ба дугаар**]-ыг [**тендерийн үнийг тоогоор болон үсгээр**] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх**
 - 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
2. **Төслийн менежерийн шийдвэр**
 - 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
3. **Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх**
 - 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
4. **Аюулгүй байдал**
 - 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
 - 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5. **Зааварчилгаа**
 - 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. **Маргааныг шийдвэрлэх**
 - 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
7. **Ажлын хөтөлбөр**
 - Б. **ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**
 - 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
 - 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. **Зөрчил, гологдол илрүүлэх**
 - 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

9. Зөрчил, гологдол арилгах

9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.

10. Зөрчил, гологдол арилгахгүй байх

10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. Үе шатны ажлын хуваарь

11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.

11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.

12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх

12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.

13. Алданги

13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги ² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.
- Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.
- Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

- (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

20. Гүйцэтгэл эс чөлөөлөх

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: **“Хөтөл дэд станц ОПУ, ЗРУ-ын дотор, барилгын дээврийн засвар, гадна фасадны засвар, барилгын хаяавч, борооны ус зайлуулах шуудуу засварлаж цутгах ажил”**

ЦДҮС-2019/ТБС-ХА-04

ГЕН 2.1 Ажил нь : **“Хөтөл дэд станц ОПУ, ЗРУ-ын дотор, барилгын дээврийн засвар, гадна фасадны засвар, барилгын хаяавч, борооны ус зайлуулах шуудуу засварлаж цутгах ажил”**

Ажлын талбай нь : Сэлэнгэ аймаг, Сайхан сум, “ЦДҮС” ТӨХК-ийн Төвийн бүсийн салбарын 110/35/6 кВ-ын Хөтөл дэд станц

ГЕН 3.1 Төслийн менежер нь: Ашиглалтын инженер А.Батбаяр

ГЕН 4.1 Зөвшөөрөл авч ажил эхлэсэн өдрөөр тооцогдоно.

Ажил эхлэх өдөр 2019 оны дугаар сарын

Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2019 оны дугаар сарын

ГЕН 7.1 Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.

ГЕН 9.1 Чанарын баталгаат хугацаа **18 сар** байна.Баталгаат хугацаанд гарсан гэмтэлийг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

Барьцаа хөрөнгө гэрээний нийт үнийн дүнгийн **5 хувь** байх бөгөөд чанарын баталгаат хугацаа дууссанаар барьцаа хөрөнгийг чөлөөлж гүйцэтгэгчид олгоно.

ГЕН 13.1 Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний нийт үнийн 0.05%байна.

Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний нийт үнийн 5%байна.

ГЕН 17.1 тгэлийн тайланг гэрээ дүгнэж ажил хүлээлцэхэд гаргаж өгнө.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

| | |
|-----------------|-----------------|
| _____ | _____ |
| (Тамга, тэмдэг) | (Тамга, тэмдэг) |
| _____ | _____ |
| (Гарын үсэг) | (Гарын үсэг) |
| _____ | _____ |
| (Албан тушаал) | (Албан тушаал) |

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай/ _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан

хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын
үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын
үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

